



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/480

Утасны дугаар 11111

Эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн зэрэг олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.13 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 491/А472 дугаар хамтарсан тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам", Эрүүл мэндийн яамны дэргэдэх Дотрын анагаах судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр протокол, Монголын мэс засалч эмч нарын холбооны шалгалтын комиссын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн зэрэг олгох 3 эмнэлгийн мэргэжилтний нэр, мэргэжлийн зэргийн төрөл, үнэмлэхийн дугаарыг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтанд дурдсан эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэргийн үнэмлэхийг журмын дагуу бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Дээрх 3 эмнэлгийн мэргэжилтэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих нэмэгдлийг тушаал гарсан өдрөөс эхлэн олгохыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081559



Мэргэжлийн зэрэг олгох эмнэлгийн мэргэжилтний нэр, мэргэжлийн зэргийн төрөл, үнэмлэхийн дугаар

№	Овог	Нэр	Байгууллага	Үндсэн мэргэшил	Регистрийн дугаар	Олгох зэрэг	Үнэмлэхийн дугаар
Дотор судлал - 2							
1	Аюурзана	Нансалмаа	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Дотрын анагаах судлал	ОЖ73100507	Тэргүүлэх	8220
2	Батаа	Банзрагч	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	Дотрын анагаах судлал	ЙЮ79102402	Тэргүүлэх	8221
Мэс засал судлал - 1							
3	Цэрэнбат	Бат-Очир	Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг	Мэс засал судлал	УХ67012552	Ахлах	8222